



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 425

Улаанбаатар хот

“Геологийн судалгаа шинжилгээний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн санг тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн “Төрийн өмчит зарим үйлдвэрийн газрын талаар авах арга хэмжээний тухай” 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Геологийн судалгаа шинжилгээний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн санг 5,749,615,242.73 (Таван тэрбум долоон зуун дөчин есөн сая зургаан зуун арван таван мянга хоёр зуун дөчин хоёр төгрөг далан гурван мөнгө) төгрөгөөр тогтоосугай.

2. Дүрмийн санг холбогдох хууль тогтоомжийн дагуу Улсын бүртгэлд бүртгүүлэхийг “Геологийн судалгаа шинжилгээний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч (Т.Бүжинлхам)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ